



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 06 сарын 14 өдөр

Дугаар 317

Улаанбаатар хот

┌ Үндсэн хөрөнгө балансаас балансад ┐
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 33,000,000.00 (гучин гурван сая) төгрөгийн балансын үнэ, 6,683,333.27 (зургаан сая зургаан зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчит байгууллагуудад балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын автобааз” төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, “Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал Ц.Батзориг, Хүүхэд залуучуудын театрын дарга Н.Ариунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

139005508
16-r huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн
 347 дугаар тогтоолын хавсралт

**"ЗАСГИЙН ГАЗРЫН АВТОБААЗ" ТӨААТҮГ-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 ТӨРИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДАД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИН**

Д/д	Автомашини марк, улсын дугаар, арлын дугаар	Үйлдвэрлэсэн/а шиглалтад орсон огноо	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэн авах байгууллага
1	Ниссан Максима, 07-69 УНУ, 1N4BA41E97C827520	2006/2007	3,000,000.00	1,683,333.27	1,316,666.73	"Орхон АЗЗА" ТӨХК
2	Соната YF, 80-97 УНА, КМННВ41ВВСА438862	2012/2012	30,000,000.00	5,000,000.00	25,000,000.00	Хүүхэд залуучуудын театр
	НИЙТ ДҮН		33,000,000.00 (гучин гурван сая)	6,683,333.27 (зургаан сая зургаан зуун наян гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг хорин долоон мянган сая зургаан зуун гурван сая гурван зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан гурван мянган мөнгө)	26,316,666.73 (хорин зургаан сая гурван зуун арван зургаан мянга зургаан зуун жаран зургаан төгрөг далан гурван мянган мөнгө)	